



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ

2025 оны 5 дугаар сар

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
СУДАЛГАА, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2025 оны 06 сарын 16
Улаанбаатар хот

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Үзүүлэлт	Тодорхойлолт*
Тээсэн ачаа	Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн ачаа нь дотроо олон төрлийн байдгаас салбаруудын онцлогоос шалтгаалан ачааг шинж чанараар нь тодорхой бүлэг, ангилалд хуваадаг. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ.
Ачаа эргэлт	Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.
Тээсэн зорчигч	Тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоог хэлнэ.
Зорчигч эргэлт	Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.
Шилжүүлсэн тн.км	Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.
Тээврийн орлого	Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэр тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм. Үүнийг тухайн оны үнээр тооцно.

*Тээврийн салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт

ТАНИЛЦСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

С.БАТБОЛД

ХЯНАСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА

Г.БАТБАЯР

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН СУДАЛГАА,
СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.МЯДАГМАА

БОЛОВСРУУЛСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН СУДАЛГАА, СТАНДАРТ,
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ц.НЭМЭХЖАРГАЛ

Энэхүү эмхэтгэлийг ҮСХ, яам, харьяа байгууллагуудын болон Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ¹ бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн гаргалаа.

¹ Зам, тээврийн салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар байгууллагуудын мэдээлэл солилцооны уялдаа холбоог бэхжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор платформыг 2022 оны 1 дүгээр сараас хөгжүүлж эхэлсэн.

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.1. АЧАА ТЭЭВЭР	6
1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР	7
БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР	8
2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА	8
2.1.1. АВТОТЭЭВРИЙН ЭКСПОРТЫН АЧАА, БООМТУУДААР.....	9
2.1.2. АВТОТЭЭВРИЙН ИМПОРТЫН АЧАА, БООМТУУДААР.....	10
2.1.3. АВТОТЭЭВРИЙН АЧААНЫ НЭР ТӨРӨЛ.....	11
2.1.4. АВТОТЭЭВРИЙН АЧАА ЭРГЭЛТ, БООМТУУДААР.....	12
2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ	12
2.3. АВТО ЗАМЫН БООМТУУДААР НЭВТЭРСЭН АЧААТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ	14
БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР.....	15
3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА	15
3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ	18
БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР.....	19
4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА	19
4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ	20
4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ	21
4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ	22
4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ.....	23

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зам, тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт.....	5
Хүснэгт 2. Автотээврийн ачаа тээвэр.....	8
Хүснэгт 3. Автотээврийн экспортын ачаа, боомтуудаар.....	9
Хүснэгт 4. Автотээврийн импортын ачаа, боомтуудаар.....	10
Хүснэгт 5. Автотээврийн ачааны нэр төрөл.....	11
Хүснэгт 6. Автотээврийн ачаа эргэлт.....	12
Хүснэгт 7. Автотээврийн зорчигч.....	12
Хүснэгт 8. Хот хоорондын нийтийн тээврийн зорчигч.....	13
Хүснэгт 9. Авто замын боомтуудаар гарсан ачаатай тээврийн хэрэгслийн бүртгэл.....	14
Хүснэгт 10. Төмөр замын ачаа тээвэр.....	15
Хүснэгт 11. Төмөр замын зорчигч тээвэр.....	18
Хүснэгт 12. Агаарын тээврийн ачаа.....	19
Хүснэгт 13. Агаарын тээврийн зорчигч.....	20
Хүснэгт 14. Агаарын тээврийн олон улсын зорчигч.....	21
Хүснэгт 15. Агаарын тээврийн орон нутгийн зорчигч.....	22
Хүснэгт 16. Нислэг гүйцэтгэл.....	23

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нийт ачаа тээвэр.....	6
Зураг 2. Нийт экспорт.....	6
Зураг 3. Нийт импорт.....	6
Зураг 4. Нийт зорчигч тээвэр.....	7
Зураг 5. Олон улсад зорчигч.....	7
Зураг 6. Орон нутагт зорчигч.....	7
Зураг 7. Автотээврээр тээвэрлэсэн ачаа, тонн, сараар.....	8
Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь.....	8
Зураг 9. Автотээврийн экспортын ачаа, тонн, боомтоор.....	9
Зураг 10. Автотээврийн импортын ачаа, тонн, боомтоор.....	10
Зураг 11. Экспортын ачааны нэр төрөл, тонн, сараар.....	11
Зураг 12. Экспортын нүүрсний хэмжээ, тонн, сараар.....	11
Зураг 13. Автотээврийн зорчигч.....	12
Зураг 14. Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл.....	14
Зураг 15.Төмөр замын ачаа	15
Зураг 16.Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	16
Зураг 17. Төмөр замын ачаа тээврийн төрөл.....	16
Зураг 18. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	16
Зураг 19. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар.....	16
Зураг 20. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2025.03.31.....	17
Зураг 21. Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор.....	17
Зураг 22. Төмөр замын зорчигч тээвэр.....	18
Зураг 23. Төмөр замын зорчигч, хоногоор.....	18
Зураг 24. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан.....	19
Зураг 25. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан.....	19
Зураг 26. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар.....	19
Зураг 27. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо.....	20
Зураг 28. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар.....	20
Зураг 29. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр.....	21
Зураг 30. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	22
Зураг 31. Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....	22
Зураг 32. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	23
Зураг 33. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар.....	23

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ²

Хүснэгт 1


№	Үзүүлэлт	Тээврийн төрөл	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
				5-р сар	Өссөн дүн	5-р сар	Өссөн дүн	
1	Тээвэрлэсэн ачаа	Автотээвэр	мян.тн	7,811.9	32,977.1	7,310.7	33,860.1	2.7%
		Төмөр зам	мян.тн	3,590.0	18,152.1	3,732.5	17,329.7	-4.5%
		Агаар	мян.тн	0.8	3.7	0.9	3.8	2.2%
		Нийт ачаа	мян.тн	11,402.7	51,133.0	11,044.0	51,193.6	0.1%
2	Дамжин өнгөрөх ачаа /транзит/	Төмөр зам	мян.тн	451.1	2,138.1	524.9	2,413.9	12.9%
3	Ачаа гаргалт /экспорт/	Төмөр зам	мян.тн	904.1	4,566.8	917.8	4,535.2	-0.7%
		Автотээвэр	мян.тн	7,502.4	31,916.6	6,982.5	32,655.0	2.3%
		Нийт	мян.тн	8,406.5	36,483.5	7,900.3	37,190.3	1.9%
4	Ачаа оруулалт /импорт/	Төмөр зам	мян.тн	294.4	1,609.3	281.7	1,448.4	-10.0%
		Автотээвэр	мян.тн	309.5	1,060.5	328.2	1,205.1	13.6%
		Нийт	мян.тн	603.9	2,669.7	609.9	2,653.5	-0.6%
5	Дотоодод тээвэрлэсэн ачаа	Төмөр зам	мян.тн	1,940.4	9,837.9	2,008.1	8,932.2	-9.2%
		Агаар	мян.тн	0.8	3.7	0.9	3.8	2.2%
		Нийт	мян.тн	1,941.2	9,841.6	2,009.0	8,936.0	-9.2%
6	Ачаа эргэлт	Автотээвэр	сая тн.км	1,207.8	5,201.2	1,099.6	5,159.6	-0.8%
		Төмөр зам	сая тн.км	1,690.9	8,712.8	1,811.8	8,730.2	0.2%
		Агаар	сая тн.км	2.3	12.1	1.9	9.6	-20.8%
		Нийт	сая тн.км	2,900.9	13,926.1	2,913.3	13,899.4	-0.2%
7	Зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	13,851.8	61,645.4	13,480.4	63,950.4	3.7%
		Төмөр зам	мян.хүн	173.2	773.7	144.1	688.2	-11.0%
		Агаар	мян.хүн	163.8	714.3	176.5	813.0	13.8%
		Нийт зорчигч	мян.хүн	14,188.9	63,133.4	13,801.0	65,451.7	3.7%
8	Олон улсад зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	67.2	275.5	51.6	219.2	-20.4%
		Төмөр зам	мян.хүн	3.5	11.0	5.2	15.1	36.4%
		Агаар	мян.хүн	126.6	546.5	140.6	644.2	17.9%
		Нийт	мян.хүн	197.3	833.0	197.4	878.5	5.5%
9	Орон нутагт зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	122.2	592.1	124.8	628.5	6.1%
		Төмөр зам	мян.хүн	169.7	762.7	138.8	673.1	-11.7%
		Агаар	мян.хүн	37.3	167.9	35.9	168.8	0.5%
		Нийт	мян.хүн	329.2	1,522.6	299.4	1,470.3	-3.4%
10	Нийслэл дэх нийтийн тээврийн зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	13,662.4	60,777.7	13,304.1	63,101.4	3.8%
11	Зорчигч эргэлт	Автотээвэр	сая хүн.км	192.1	888.6	187.4	868.1	-2.3%
		Төмөр зам	сая хүн.км	65.8	306.3	58.5	288.6	-5.8%
		Агаар	сая хүн.км	348.4	1,647.8	373.1	1,969.4	19.5%
		Нийт	сая хүн.км	606.3	2,842.7	619.0	3,126.0	10.0%
12	Агаарын тээврийн нислэгийн тоо	Олон улсын хөөрөлт, буултын тоо	ш	1,030.0	4,312.0	1,112	4,855	12.6%
		Орон нутгийн хөөрөлт, буултын тоо	ш	929.0	3,353.0	892	3,768	12.4%
		Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо	ш	5,298.0	25,295.0	6,605	31,106	23.0%
13	Авто замын боомтуудаар гарсан ачаатай тээврийн хэрэгсэл	ш	ш	70,727.0	303,638.0	60,466.0	298,151.0	-1.8%
14	Авто замын боомтуудаар орсон ачаатай тээврийн хэрэгсэл	ш	ш	13,451.0	45,505.0	16,023.0	62,802.0	38.0%

² Зам, тээврийн салбарын 2025 оны 5 дугаар сарын статистикийн мэдээг 2025 оны 6 дугаар сарын 16-ны өдөр гаргав.

1.1. АЧАА ТЭЭВЭР

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2025 оны 5 дугаар сард 11.0 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 3.1%-аар өссөн байна. Харин 2025 оны өссөн дүнгээр буюу эхний 5 сард нийт 51.2 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 0.1%-аар өссөн байна.


- Автотээврээр 2025 оны 5 дугаар сард автотээврээр 7.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 6.4%-аар өссөн байна. Эхний 5 сарын байдлаар автотээврээр нийт 33.9 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 2.7%-аар, экспортын ачаа 32.7 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 2.3%-аар, импортын ачаа 1.2 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 13.6%-аар тус тус өссөн байна.
- Төмөр замын тээврээр Төмөр замын тээврээр 2025 оны 5 дугаар сард нийт 3.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 4%-аар өсжээ. Нийт өссөн дүнгээр 17.3 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.5%-аар буурсан. Үүнээс дотоодын ачаа 8.9 сая тонн болж 9.2%-аар, экспортын ачаа 4.5 сая тонн 0.7%-аар, импортын ачаа 1.4 сая тонн болж 10.0%-аар тус тус буурсан бол дамжин өнгөрсөн ачаа 2.4 сая тонн болж 12.9%-аар өссөн байна.
- Агаарын тээврээр 2025 оны 5 дугаар сард 883.3 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 12.6%-аар өссөн. Харин өссөн дүнгээр 3813.5 тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 2.2%-аар өссөн байна. Үүнээс ачаа 3733.2 тонн тээвэрлэсэн нь 2.7%-аар өссөн бол шуудан 80.4 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 16.2%-аар буурсан байна..



Экспортоор 5 дугаар сард 7.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 6%-аар буурсан байна. Харин 2025 оны өссөн дүнгээр экспортын хэмжээ 37.2 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 1.9%-аар өссөн байна. Үүнээс төмөр замаар 4.5 сая тонн тээвэрлэсэн нь 0.7%-аар буурсан бол автотээврээр 32.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.3%-аар өссөн байна. Нийт экспортын дүнд автотээвэр 88%-ийг, төмөр зам 12%-ийг эзэлж байна. /Зураг 2/

Импортын ачаа 2025 оны 5 дугаар сард нийт 609.9 мянган тонн болж өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 1.0%-аар өссөн. Харин нийт өссөн дүнгээр 2.7 сая тонн ачаа импортолсон нь өмнөх оны мөн үеэс 0.6%-аар буурчээ. Үүнээс төмөр замаар 1.4 сая тонн ачаа импортолсон нь 10.0%-аар буурсан бол автотээврээр 1.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 13.6%-аар өссөн байна. Импортын тээврийн 55%-ийг төмөр замаар, 45%-ийг автотээврээр тээсэн байна.

Зураг 3. Нийт импорт




1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР


Бүх төрлийн тээврээр 2025 оны 5 дугаар сард 13.8 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 2.7%-аар буурсан. 2025 оны өссөн дүнгээр буюу эхний 5 сард 65.5 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 3.7%-аар өссөн үзүүлэлттэй байна.

- Автотээврээр 2025 оны 5 дугаар сард 13.3 сая зорчигч зорчсон нь өмнөх оны 5 дугаар сараас 2.6%-аар буурсан байна. Өссөн дүнгээр нийт 64 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 3.7%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр 63.1 сая зорчигч (+3.8%), орон нутагт 628.5 мянган зорчигч (+6.1%), олон улсад 219.2 мянган зорчигч (-20.4%) зорчжээ. /Доорх графикт нийслэлийн нийтийн тээврийн зорчигчийг хассан болно./
- Төмөр замаар 2025 оны 5 дугаар сард нийт 144.1 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 16.8%-аар буурсан. Нийт өссөн дүнгээр 688.2 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 11%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 15.1 мянган зорчигч зорчсон нь 36.4%-аар өссөн бол харин орон нутагт 673.1 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 11.7%-аар буурсан байна.
- Агаарын тээврээр 2025 оны 5 дугаар сард нийт 176.5 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 7.7%-аар өссөн. Өссөн дүнгээр нийт 813 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 13.8%-аар өссөн бол үүнээс олон улсад 644.2 мянган зорчигч зорчсон нь 17.9%-аар, орон нутагт 168.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 0.5%-аар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 4. Нийт зорчигч тээвэр, мян. хүн




Зураг 5. Олон улсын зорчигч



2025 оны эхний 5 сард олон улсад нийт 878.5 мянган зорчигч (+5.5%) зорчсон бөгөөд үүнээс агаарын тээврээр 644.2 мянган зорчигч (+17.9%), автотээврээр 219.2 мянган зорчигч (-20.4%), төмөр замаар 15.1 мянган зорчигч (+36.4%) тус тус зорчсон байна. Олон улсад зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 73%, автотээвэр 25%, төмөр зам 2%-ийг эзэлж байна. /Зураг 5/

2025 оны эхний 5 сард орон нутагт нийт 1.5 сая зорчигч (-3.4%) зорчсон бөгөөд үүнээс автотээврээр 628.5 мянган зорчигч (+6.1%), төмөр замаар 673.1 мянган зорчигч (-11.7%), агаарын тээврээр 168.8 мянган зорчигч (+0.5%) тус тус зорчоод байна. Орон нутагт зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 11%, автотээвэр 44%, төмөр зам 45%-ийг эзэлж байна. /Зураг 6/

Зураг 6. Орон нутагт зорчигч



БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР

2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА³


2025 оны өссөн дүнгээр авто замаар нийт 33.9 сая тонн ачаа тээвэрлэснээс 32.7 сая тонн ачаа экспортолсон байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Хүснэгт 2 Өсөлт бууралтын %/өссөн дүн/
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Нийт ачаа	тонн	7,811,911.8	32,977,077.5	7,310,658.0	33,860,142.0	2.7%
Импорт	тонн	309,492.5	1,060,455.6	328,201.0	1,205,100.0	13.6%
Экспорт	тонн	7,502,419.3	31,916,622.0	6,982,457.0	32,655,042.0	2.3%
Ачаа эргэлт	тн.км	1,207,785,736.3	5,201,201,664.7	1,099,567,461.0	5,159,649,921.0	-0.8%

2025 оны 5 дугаар сард автотээврээр 7.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 6.4%-аар өссөн байна. Үүнээс экспортод 7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 6.9%-аар буурсан бол импортоор 328.2 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 5 дугаар сараас 6%-аар өссөн үзүүлэлттэй байна. Харин ачаа эргэлт 5 дугаар сард 1.1 тэрбум тонн км болсон нь өмнөх оны 5 дугаар сараас 9%-аар буурсан байна.

Сар бүр тээвэрлэсэн нийт ачааны хэмжээг зураг 7-д харуулав.

Зураг 7 . Автотээврээр тээвэрлэсэн ачаа, тонн, сараар



Эхний 5 сарын байдлаар автотээврээр нийт 33.9 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 2.7%-аар, экспортын ачаа 32.7 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 2.3%-аар, импортын ачаа 1.2 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 13.6%-аар тус тус өссөн байна. Ачаа эргэлт 5.2 тэрбум тонн км болж өмнөх оны мөн үеэс 0.8%-аар буурсан байна.

2025 оны өссөн дүнгээр нийт ачаа тээврийн 32.7 сая тонн буюу 96%-ийг экспортын ачаа, 1.2 сая тонн буюу 4%-ийг импортын ачаа эзэлж байна. Экспортын ачаанд уул уурхайн бүтээгдэхүүний ачаа дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд Гашуунсухайт боомтоор экспортын ачааны 48%-ийг нэвтрүүлсэн байна. Харин импортын ачааны 76%-ийг Замын-Үүд боомтоор оруулж ирсэн ачаа эзэлж байна. /Зураг 8/

Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь




³ "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын статистикийн мэдээ

2.1.1. АВТОТЭЭВРИЙН ЭКСПОРТЫН АЧАА, БООМТУУДААР

Хүснэгт 3

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
			5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа тээвэр	тонн	7,811,911.8	32,977,077.5	7,310,658.0	33,860,142.0	2.7%
2	Экспорт-боомтуудаар	тонн	7,502,419.3	31,916,622.0	6,982,457.0	32,655,042.0	2.3%
3	ОХУ-руу	тонн	2,328.9	16,420.3	7,714.0	40,856.0	148.8%
4	Алтанбулаг	тонн	2,328.9	16,420.3	7,714.0	40,856.0	148.8%
5	Боршоо	тонн	0.0	0.0	0.0	0.0	-
6	Цагаан нуур	тонн	0.0	0.0	0.0	0.0	-
7	БНХАУ-руу	тонн	7,500,090.4	31,900,201.7	6,974,743.0	32,614,186.0	2.2%
8	Бичигт	тонн	312,064.0	982,509.0	204,878.0	2,421,423.0	146.5%
9	Баянхошуу	тонн	25,738.0	194,844.6	34,993.0	173,066.0	-11.2%
10	Бургастай	тонн	34,325.3	188,427.3	0.0	29,742.0	-84.2%
11	Булган	тонн	414,760.0	1,387,006.0	347,336.0	1,306,417.0	-5.8%
12	Гашуунсухайт	тонн	3,671,557.2	16,537,699.6	3,238,119.0	15,785,275.0	-4.5%
13	Замын-Үүд	тонн	72,185.0	363,921.0	58,208.0	255,600.0	-29.8%
14	Ханги	тонн	743,552.9	3,184,094.3	373,085.0	2,137,873.0	-32.9%
15	Хавирга	тонн	0.0	9,452.9	8,170.0	39,389.0	316.7%
16	Шивээ хүрэн	тонн	2,225,908.0	9,052,247.0	2,709,954.0	10,465,401.0	15.6%
17	Сүмбэр	тонн	0.0	0.0	0.0	0.0	-

Зураг 9. Автотээврийн экспортын ачаа, тонн, боомтоор



ОХУ-тай хиллэдэг Алтанбулаг боомтоор 2025 оны 5 дугаар сард 7.7 мянган тонн ачаа, харин эхний 5 сарын байдлаар 40.9 мянган тонн ачаа гарсан нь өмнөх оны мөн үеэс 2.5 дахин өссөн байна.

БНХАУ-тай хиллэдэг боомтуудаар 5 дугаар сард 6.97 сая тонн ачаа, харин өссөн дүнгээр 32.6 сая тонн ачаа гарсан нь 2.2%-аар өссөн байна. Үүнээс хамгийн их ачааг Гашуунсухайт боомтоор нэвтрүүлсэн бөгөөд 15.8 сая тонн (-4.5%) ачаа тээвэрлэсэн нь нийт экспортын 48%-ийг дангаараа бүрдүүлж байна. Шивээхүрэн боомтоор 10.5 сая тонн (+15.6%), Бичигт боомтоор 2.4 сая тонн (+146.5%), Ханги боомтоор 2.1 сая тонн (-32.9%), Булган боомтоор 1.3 сая тонн (-5.8%), Замын-Үүд боомтоор 255.6 мянган тонн (-29.8%), Баянхошуу боомтоор 173.1 мянган тонн (-11.2%), Хавирга боомтоор 39.4 мянган тонн (+316.7%), Бургастай боомтоор 29.7 мянган тонн (-84.2%) ачаа тус тус экспортод гарсан байна. /Зураг 9/

2.1.2 АВТОТЭЭВРИЙН ИМПОРТЫН АЧАА, БООМТУУДААР

Хүснэгт 4

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
			5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа тээвэр	тонн	7,811,911.8	32,977,077.5	7,310,658.0	33,860,142.0	2.7%
2	Импорт –боомтуудаар	тонн	309,492.5	1,060,455.6	328,201.0	1,205,100.0	13.6%
3	ОХУ-аас	тонн	35,137.0	166,443.2	21,144.0	136,892.0	-17.8%
4	Алтанбулаг	тонн	21,049.4	81,150.3	17,724.0	110,662.0	36.4%
5	Боршоо	тонн	3,366.5	21,124.3	1,933.0	11,817.0	-44.1%
6	Цагаан нуур	тонн	10,721.1	64,168.6	1,487.0	16,715.0	-74.0%
7	БНХАУ-аас	тонн	274,355.5	894,012.4	307,057.0	1,068,208.0	19.5%
8	Бичигт	тонн	741.0	2,988.0	0.0	0.0	-100.0%
9	Баянхошуу	тонн	7.4	45.4	632.0	652.0	1336.1%
10	Бургастай	тонн	196.0	280.0	0.0	0.0	-100.0%
11	Булган	тонн	0.0	0.0	0.0	0.0	-
12	Гашуунсухайт	тонн	42,160.0	89,600.0	28,840.0	106,920.0	19.3%
13	Замын-Үүд	тонн	212,688.0	740,893.5	267,314.0	921,498.0	24.4%
14	Ханги	тонн	1,525.0	5,450.0	2,240.0	5,865.0	7.6%
15	Хавирга	тонн	6,278.1	14,515.5	1,511.0	6,073.0	-58.2%
16	Шивээ хүрэн	тонн	10,760.0	40,240.0	6,520.0	27,200.0	-32.4%

Автотээвэрээр 2025 оны 5 дугаар сард импортоор 328.2 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 21.1 мянган тонныг ОХУ-аас, 307.1 мянган тонн ачааг БНХАУ-аас оруулж ирсэн байна.

Харин өссөн дүнгээр импортын ачаа 1.2 сая тонн байснаас 136.9 мянган тонныг ОХУ-аас оруулж ирсэн нь өмнөх оны мөн үеэс 17.8%-аар буурсан бол 1.1 сая тонн ачааг БНХАУ-аас оруулж ирсэн нь өмнөх оны мөн үеэс 19.5%-аар өссөн байна.

Зураг 10. Автотээврийн импортын ачаа, тонн, боомтоор

2025 оны өссөн дүнгээр ОХУ-аас 136.9 мянган тонн ачаа оруулж ирснээс Алтанбулаг боомтоор 110.7 мянган тонн (+36.4%), Цагааннуур боомтоор 16.7 мянган тонн (-74%), Боршоо боомтоор 11.8 мянган тонн (-44.1%) ачаа тус тус орж иржээ.

БНХАУ-аас 1.1 сая тонн ачаа оруулж ирснээс Замын-Үүд боомтоор 921.5 мянган тонн ачаа (+24.4%), Гашуунсухайт боомтоор 106.9 мянган тонн ачаа (+19.3%), Шивээхүрэн боомтоор 27.2 мянган тонн ачаа (-32.4%), Хавирга боомтоор 6.1 тонн ачаа (-58.2%), Ханги боомтоор 5.9 мянган тонн ачаа (+7.6%) оруулсан байна.

Импортын ачааны 89%-ийг БНХАУ-аас, 11%-ийг ОХУ-аас оруулж ирсэн. **Нийт импортын ачааны 76%-ийг Замын-Үүд боомтоор оруулж байна.** /Зураг 10/



■ 2025 оны эхний 5 сар ■ 2024 оны эхний 5 сар

2.1.3. АВТОТЭЭВРИЙН АЧААНЫ НЭР ТӨРӨЛ


Хүснэгт 5

Ачааны нэр төрлөөр	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Нүүрс	тонн	7,309,090.3	30,983,088.0	6,723,447.8	31,566,295.7	1.9%
Газрын тос	тонн	25,737.8	194,844.4	34,993.5	173,067.5	-11.2%
Зэсийн баяжмал	тонн	89,430.0	386,007.0	152,513.5	589,367.8	52.7%
Төмрийн хүдэр	тонн	59,352.2	257,670.7	21,234.0	92,768.5	-64.0%
Жонш	тонн	9,386.2	39,501.2	35,783.0	150,320.9	280.5%
Цайр	тонн	0.0	2,699.0	0.0	0.0	-100.0%
Бусад	тонн	9,422.8	52,811.7	14,485.2	83,221.6	57.6%

Авто замын боомтуудаар гарсан ачааг нэр төрлөөр авч үзвэл 5 дугаар сард нүүрс 6.7 сая тонн (-8.0%), зэсийн баяжмал 152.5 мянган тонн (+70.5%), газрын тос 34.9 мянган тонн (+36.0%), төмрийн хүдэр 21.2 мянган тонн (-64.2%), жонш 35.8 мянган тонн (+281.2%), бусад ачаа 14.5 мянган тонн ачаа (+53.7%) гаргасан байна.


2025 оны өссөн дүнгээр нийт нүүрс 31.6 сая тонн (+1.9%), зэсийн баяжмал 589.4 мянган тонн (+52.7%), төмрийн хүдэр 92.8 мянган тонн (-64.0%), газрын тос 173.1 мянган тонн (-11.2%), жонш 150.3 мянган тонн (+280.5%), бусад 83.2 мянган тонн ачаа (+57.6%) тус тус экспортод тээвэрлэжээ. /Зураг 11/

Зураг 11. Экспортын ачааны нэр төрөл, тонн, сараар



Авто замын боомтуудаар экспортод гарсан нүүрсний хэмжээг доорх графикт харуулав. 2025 оны 5 дугаар сард 6.7 сая тонн гарсан нь өмнөх оны 5 дугаар сараас 8%-аар буурсан. Харин өссөн дүнгээр 31.6 сая тонн нүүрс гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9%-аар өссөн байна. /Зураг 12/

Зураг 12. Экспортын нүүрсний хэмжээ, тонн, сараар



2.1.4. АВТОТЭЭВРИЙН АЧАА ЭРГЭЛТ, БООМТУУДААР


№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Хүснэгт 6 Өсөлт бууралтын %/өссөн дүн/
			5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа эргэлт	тн.км	1,207,785,736.3	5,201,201,664.7	1,099,567,461.0	5,159,649,921.0	-0.8%
2	Алтанбулаг	тн.км	537,700.9	2,244,122.7	585,074.0	3,484,914.0	55.3%
3	Бичигт	тн.км	25,024,400.0	78,839,760.0	16,390,240.0	193,713,840.0	145.7%
4	Баянхошуу	тн.км	16,477,056.0	124,729,600.0	22,800,000.0	111,179,520.0	-10.9%
5	Бургастай	тн.км	2,761,704.0	15,096,584.0	0.0	2,379,360.0	-84.2%
6	Гашуунсухайт	тн.км	854,154,956.0	3,824,278,908.0	751,400,570.0	3,655,204,850.0	-4.4%
7	Замын-Үүд	тн.км	1,994,111.0	7,733,701.5	2,278,654.0	8,239,686.0	6.5%
8	Цагааннуур	тн.км	1,072,110.0	6,416,860.0	148,700.0	1,671,500.0	-74.0%
9	Ханги	тн.км	14,901,558.0	63,790,886.0	7,506,500.0	42,874,760.0	-32.8%
10	Шивээ хүрэн	тн.км	145,383,420.0	591,011,655.0	176,570,810.0	682,019,065.0	15.4%
11	Хавирга	тн.км	144,395.4	551,272.5	222,663.0	1,045,626.0	89.7%
12	Булган	тн.км	145,166,000.0	485,452,100.0	121,567,600.0	457,245,950.0	-5.8%
13	Боршоо	тн.км	168,325.0	1,056,215.0	96,650.0	590,850.0	-44.1%

2025 оны өссөн дүнгээр автотээврийн ачаа эргэлт нийт 5.2 тэрбум тонн км ачаа болсон нь өмнөх оны мөн үеэс 0.8%-аар буурсан байна. Үүнээс Гашуунсухайт боомтоор ачаа эргэлт хамгийн их байгаа бөгөөд 3.7 тэрбум тонн км байгаа нь нийт ачаа эргэлтийн 71%-ийг дангаар бүрдүүлж байна. /Хүснэгт 6/

2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Хүснэгт 7 Өсөлт бууралтын %/өссөн дүн/
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Нийт зорчигч	хүн	13,851,790.0	61,645,363.0	13,480,423.0	63,950,439.0	3.7%
Олон улсад	хүн	67,217.0	275,537.0	51,574.0	219,207.0	-20.4%
Хот хоорондын	хүн	122,177.0	592,093.0	124,750.0	628,481.0	6.1%
Хот доторх нийтийн тээврээр зорчигч	хүн	13,662,396.0	60,777,733.0	13,304,099.0	63,101,389.0	3.8%
Зорчигч эргэлт	сая хүн.км	192.1	888.6	187.4	868.1	-2.3%

Зураг 13. Зорчигч тээвэр



Автотээврээр 2025 оны 5 дугаар сард 13.3 сая зорчигч зорчсон нь өмнөх оны 5 дугаар сараас 2.6%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 51.6 мянган зорчигч (-23.3%), орон нутагт 124.8 мянган зорчигч (+2.1%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 13.3 сая зорчигч (-2.6%) тус тус зорчсон байна.

Өссөн дүнгээр нийт 64 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 3.7%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр 63.1 сая зорчигч (+3.8%), орон нутагт 628.5 мянган зорчигч (+6.1%), олон улсад 219.2 мянган зорчигч (-20.4%) зорчжээ.

Автотээврийн зорчигчийн 98.7%-ийг нийслэлийн нийтийн тээвэр, 1.0%-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.3%-ийг олон улсын зорчигчид эзэлж байна. /Зураг 13/

Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл – 2025 оны 5 дугаар сар

Хүснэгт 8

№	Аймгийн нэр	№	Сум дүүргийн нэр	Тээвэрлэлтийн зай	Тээврийн хэрэгслийн төрөл	5-сар				
						Суудал ашиглалт	Рейс	Зорчигч		
								УБ-аас гарсан	ОН-аас ирсэн	Бүгд
0	1	2	3	4	5	11	12	13	14	15
1	Архангай	1	Цэцэрлэг	560	том оврын	59.8	5	144	125	269
		2	Эрдэнэбулган	498	том оврын	58.2	93	2514	2330	4844
		3	Тариат	647	том оврын	15.9	4.5	39	24	63
		4	Жаргалант	571	том оврын	57.1	4.5	129	97	226
		5	Эрдэнэмандал	511	том оврын	33.1	4	84	35	119
2	Баян-Өлгий	6	Өлгий-сум	1709	том оврын	75.3	59	1844	2063	3907
3	Баянхонгор	7	Баянхонгор	640	том оврын	75.1	107	3526	3546	7072
4	Булган	8	Булган	438	том оврын	51.2	31	714	715	1429
5	Говь-Алтай	9	Есөнбулаг	1037	том оврын	70.5	62	1992	1853	3845
		10	Бигэр	1247	том оврын					
6	Дархан-Уул	11		219	том оврын	49	248.5	6345	4614	10959
		12	Дархан	219	суудлын	95	155.5	584	598	1182
		13	Шарын гол	279	том оврын					0
7	Дорнод	14	Баян-Уул	600	том оврын	41.16%	5	89	74	163
		15	Хэрлэн сум	658	том оврын	69.16%	82	2861	2797	5658
8	Дундговь	16	Эрдэнэдалай	375	том оврын					
		17	Сайхан Овоо	505	том оврын					
9	Завхан	18	Улиастай	1023	том оврын	76.4	69	2286	2170	4456
		19	Тосонцэнгэл	838	том оврын	74.3	31	972	1056	2028
		20	Тэс	1114	том оврын	52	8.5	202	187	389
		21	Отгон	1037	том оврын	64.6	4.5	139	117	256
10	Орхон	22		378	том оврын	61.8	1813	5418	4716	10134
		23	Баян-Өндөр	378	суудлын	84.9	187.5	510	763	1273
11	Өвөрхангай	24	Арвайхээр	431	том оврын	52.1	107.5	2430	2583	5013
		25	Хужирт	384	том оврын	46	27	636	481	1117
		26	Хархорин	365	том оврын	54.4	31	741	776	1517
		27	Сант	409	том оврын	41.1	5	130	55	185
		28	Бат-Өлзий	433	том оврын	55	17	394	447	841
12	Өмнөговь	29	Даланзадгад	575	том оврын	52.5	16.5	425	354	779
		30	Цогтцэций	544	том оврын	69.3	124	4069	3574	7643
		31	Цагаанхад	933	том оврын	71.5	31	1082	869	1951
			Гурван тэс		том оврын	25.8	9.5	167	49	216
13	Дорноговь	32	Сайншанд	450	том оврын	58.95%	31	961	679	1640
		33	Замын-Үүд	660	том оврын					
14	Сүхбаатар	34	Баруун-Урт	565	том оврын	67.00%	62	1948	1749	3697
		35	Дарьганга	710	том оврын					
		36	Эрдэнэцагаан	768	том оврын	49.87%	9	232	163	395
15	Сэлэнгэ	37	Сүхбаатар	343	том оврын	77.1	32.5	1265	940	2205
16	Төв	38	Борнуур	102	дунд оврын	8.6	2	5	1	6
		39	Зуунмод	43	дунд оврын	73.1	340	2721	2749	5470
		40	Батсүмбэр	79	дунд оврын	58.8	62	605	549	1154
		41	Баянчандмань		дунд оврын	53.8	61.5	863	728	1591
		42	Жаргалант	128	дунд оврын	44.5	30	335	307	642
17	Ховд	43	Хо.Жаргалант	1488	том оврын	55	101	2265	2451	4716
		44	Хо.Булган	1720	том оврын	49.4	17.5	347	414	761
18	Хэнтий	45	Өндөрхаан	338	том оврын	53.21%	62	1522	1447	2969
		46	Бор өндөр	348	том оврын					
		47	Хэ.Батноров	443	том оврын					
19	Хөвсгөл	48	Мөрөн	788	том оврын	68.4	188	5957	5413	11370
		49	Галт	920	дунд оврын	75	1	41	25	66
		50	Хатгал							
20	Увс	51	Улаангом	1382	том оврын	68	110	3195	3073	6268
		52	Ув.Өмнөговь	1367	том оврын	51.4	5	101	125	226
		53	Өндөрхангай	1165	том оврын	34.3	5	71	80	151
		54	Зүүнговь	1280	том оврын	87.3	5	193	191	384
21	ОХУ	55	Улан-Үд	600	том оврын	35.7	39.5	741	499	1240
22	БНХАУ	56	Эрээн	676	том оврын	45.16%	57	1255	1010	2265
Нийт дүн				35,918			4564	65089	59661	124750


2025 оны 5 дугаар сард орон нутагт автотээвэрээр нийт 124.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны 5 дугаар сараас 2.1%-аар өссөн байна. Өссөн дүнгээр буюу эхний 5 сард 628.5 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 6.1%-аар өссөн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг дээрх хүснэгтэд харуулав. ⁴

⁴ “Автотээврийн Үндэсний төв” ТӨҮГ-ийн статистикийн мэдээ

2.3. АВТО ЗАМЫН БООМТУУДААР НЭВТЭРСЭН АЧААТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ

Авто замын боомтуудаар нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн тоо	2024 он		2025 он		Хүснэгт 9
	5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	Өсөлт бууралтын % /өссөн дүн/
	84,178	349,143.0	76,489.0	360,953.0	3.4%
Орсон тээврийн хэрэгсэл	13,451	45,505.0	16,023.0	62,802.0	38.0%
БНХАУ-аас	10,433	34,836.0	12,960.0	48,934.0	40.5%
Бичигт	0.0	0.0	0.0	0.0	-
Баянхошуу	17.0	20.0	25.0	27.0	35.0%
Булган	0.0	0.0	0.0	0.0	-
Бургастай	6.0	9.0	0.0	0.0	-100.0%
Гашуунсухайт	1,054.0	2,240.0	721.0	2,673.0	19.3%
Шивээхүрэн	269.0	1,006.0	163.0	680.0	-32.4%
Замын-Үүд	8,917.0	31,055.0	11,921.0	44,720.0	44.0%
Ханги	61.0	218.0	56.0	165.0	-24.3%
Хавирга	109.0	288.0	74.0	669.0	132.3%
ОХУ-аас	3,018	10,669.0	3,063.0	13,868.0	30.0%
Алтанбулаг	1,275.0	5,041.0	1,262.0	7,357.0	45.9%
Боршоо	137.0	914.0	79.0	514.0	-43.8%
Цагааннуур	1,606.0	4,714.0	1,722.0	5,997.0	27.2%
Гарсан тээврийн хэрэгсэл	70,727	303,638.0	60,466.0	298,151.0	-1.8%
БНХАУ-руу	67,388	291,652.0	57,574.0	270,837.0	-7.1%
Бичигт	4,117.0	13,188.0	1,873.0	23,180.0	75.8%
Баянхошуу	1,118.0	5,933.0	990.0	5,340.0	-10.0%
Булган	5,670.0	19,123.0	4,893.0	18,423.0	-3.7%
Бургастай	1,060.0	5,984.0	0.0	491.0	-91.8%
Гашуунсухайт	29,835.0	132,922.0	26,325.0	127,693.0	-3.9%
Шивээхүрэн	16,706.0	72,723.0	19,715.0	74,953.0	3.1%
Замын-Үүд	1,146.0	5,712.0	861.0	3,863.0	-32.4%
Ханги	7,736.0	35,956.0	2,851.0	16,553.0	-54.0%
Хавирга	0.0	111.0	66.0	341.0	207.2%
Сүмбэр	0.0	0.0	0.0	0.0	-
ОХУ-руу	3,339	11,986.0	2,892.0	27,314.0	127.9%
Алтанбулаг	1,061.0	4,297.0	990.0	20,228.0	370.7%
Боршоо	164.0	906.0	83.0	505.0	-44.3%
Цагааннуур	2,114.0	6,783.0	1,819.0	6,581.0	-3.0%

Зураг 14. Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл



Монгол Улсын авто замын боомтуудаар 2025 оны 5 дугаар сард нийт 76.5 мянган ачаатай тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 9.1%-аар буурчээ. Үүнээс 16 мянган тээврийн хэрэгсэл орсон нь өмнөх оны 5 дугаар сараас 19.1%-аар өссөн бол 60.5 мянган тээврийн хэрэгсэл гарсан нь өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 14.5%-аар буурсан үзүүлэлттэй байна. /Хүснэгт 9/

Оны эхнээс өссөн дүнгээр нийт 360.9 мянган ачаатай тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 3.4%-аар өссөн байна. Үүнээс орсон ачаатай тээврийн хэрэгсэл 62.8 мянга болж өмнөх оны мөн үеэс 38%-аар өссөн бол гарсан тээврийн хэрэгсэл 298.2 мянга болж өмнөх оны мөн үеэс 1.8%-аар буурсан үзүүлэлттэй байна. /Зураг 14/

БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР

3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА

Төмөр замын тээврээр 2025 оны өссөн дүнгээр нийт 13.6 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.6%-аар буурлаа.


Хүснэгт 10

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % / өссөн дүн/
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Ачаа тээвэрлэлт	мян.тн	3,590.0	18,152.1	3,732.5	17,329.7	-4.5%
"Улаанбаатар төмөр зам" ХНН	мян.тн	2,615.6	13,918.5	2,611.5	13,369.3	-3.9%
"Монголын төмөр зам" ТӨХК	мян.тн	219.7	950.8	383.2	1,157.6	21.7%
"Тавантолгой төмөр зам" ХХК	мян.тн	382.7	1,434.0	138.2	695.7	-51.5%
"Монголиантранс Логистик" ХХК	мян.тн	242.1	1,437.5	359.0	1,605.3	11.7%
"Монголиантранс Лайн" ХХК	мян.тн	130.0	411.3	240.5	501.8	22.0%
Дотоодын ачаа	мян.тн	1,940.4	9,837.9	2,008.1	8,932.2	-9.2%
"Улаанбаатар төмөр зам" ХНН	мян.тн	966.0	5,604.3	887.1	4,971.8	-11.3%
үүнээс "Монголын төмөр зам" ТӨХК	мян.тн	219.7	950.8	383.2	1,157.6	21.7%
"Тавантолгой төмөр зам" ХХК	мян.тн	382.7	1,434.0	138.2	695.7	-51.5%
"Монголиантранс Логистик" ХХК	мян.тн	242.1	1,437.5	359.0	1,605.3	11.7%
"Монголиантранс Лайн" ХХК	мян.тн	130.0	411.3	240.5	501.8	22.0%
Импорт ачаа	мян.тн	294.4	1,609.3	281.7	1,448.4	-10.0%
БНХАУ-аас	мян.тн	61.4	422.9	79.7	361.0	-14.7%
ОХУ-руу	мян.тн	233.0	1,186.4	202.0	1,087.4	-8.3%
Экспорт ачаа	мян.тн	904.1	4,566.8	917.8	4,535.2	-0.7%
БНХАУ-руу	мян.тн	889.8	4,495.1	900.7	4,466.6	-0.6%
ОХУ-руу	мян.тн	14.3	71.8	17.1	68.6	-4.4%
Дамжин өнгөрөх ачаа	мян.тн	451.1	2,138.1	524.9	2,413.9	12.9%
БНХАУ-аас ОХУ-руу	мян.тн	143.2	649.0	159.8	696.4	7.3%
ОХУ-аас БНХАУ-руу	мян.тн	308.0	1,489.1	365.1	1,717.5	15.3%
Ачаа эргэлт	сая.тн-км	1,690.9	8,712.8	1,811.8	8,730.2	0.2%


Төмөр замын тээврээр 2025 оны 5 дугаар сард нийт 3.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 4%-аар өсжээ. Үүнээс дотоодын ачаа 2 сая тонн болж өмнөх оны 5 дугаар сараас 3.5%-аар, экспортын ачаа 917.8 мянган тонн болж 1.5%-аар, дамжин өнгөрсөн ачаа 524.9 мянган тонн болж 16.3%-аар тус тус өссөн бол импортын ачаа 281.7 мянган тонн болж 4.3%-аар буурсан үзүүлэлттэй байна. /Хүснэгт 11/

2025 оны өссөн дүнгээр нийт 17.3 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.5%-аар буурсан. Үүнээс дотоодын ачаа 8.9 сая тонн болж 9.2%-аар, экспортын ачаа 4.5 сая тонн 0.7%-аар, импортын ачаа 1.4 сая тонн болж 10.0%-аар тус тус буурсан бол дамжин өнгөрсөн ачаа 2.4 сая тонн болж 12.9%-аар өссөн байна. /Зураг 15/

Зураг 15. Төмөр замын ачаа, мян.тн




Зураг 16. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь



Эхний 5 сарын байдлаарх нийт ачаа тээврийн 13.4 сая тонн буюу 77%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 1.6 сая тонн буюу 9%-ийн ачааг "Монголиантранс Логистик" ХХК, 1.2 сая тонн буюу 7%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 695.7 мянган тонн буюу 4%-ийн ачааг "Тавантолгой төмөр зам" ХХК, 501.8 мянган тонн ачаа буюу нийт ачааны 3%-ийг "Монголиантранс Лайн" ХХК-иуд тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 16/

Зураг 17. Төмөр замын ачаа тээврийн төрөл



Ачаа тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл нийт ачаа тээврийн 8.9 сая тонн буюу 52%-ийг дотоодын ачаа, 4.5 сая тонн буюу 26%-ийг экспортын ачаа, 2.4 сая тонн буюу 14%-ийг дамжин өнгөрсөн ачаа, 1.4 сая тонн буюу 8%-ийг импортын ачаа тээвэр эзэлж байна. /Зураг 17/


Зураг 18. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь




Дотоодод тээвэрлэсэн 8.9 сая тонн ачааны 4.9 сая тонн ачаа буюу 56%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 1.6 сая тонн ачаа буюу 18%-ийг "Монголиантранс Логистик" ХХК, 1.2 сая тонн буюу 13%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 695.7 мянган тонн ачаа буюу 8%-ийг "Тавантолгой төмөр зам" ХХК, 501.8 мянган тонн буюу 5%-ийг "Монголиантранс Лайн" ХХК тус тус эзэлж байна. /Зураг 18/

2025 оны 5 дугаар сарын байдлаар байгууллагуудын ачаа тээврийн хоногийн дундажийг тооцоход "УБТЗ" ХНН хоногт дунджаар 84.2 мянган тонн, "МТЛогистик" ХХК нь 11.6 мянган тонн, "МТЗ" ТӨХК нь 12.4 мянган тонн, "ТТЗ" ХХК нь 4.5 мянган тонн, "МТЛайн" ХХК нь 7.8 мянган тонн ачаа тээвэрлэж байна. /Зураг 19/

Зураг 19. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар




Зураг 20. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2025.04.30



Төмөр замын байгууллагуудаар өдөр бүр тээвэрлэсэн ачааны хэмжээг төрлөөр нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформоос оруулав. 2025 оны 5 дугаар сарын байдлаар өдөрт дундажаар орон нутгийн ачаа 64.8 мянга, экспортын ачаа 29.6 мянга, дамжин өнгөрсөн ачаа 16.9 мянга, импортод дундажаар 9.1 мянган ачаа тээвэрлэсэн байна. /Зураг 20/

Зураг 21 . Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор




2025 оны эхний 4 сар буюу 2025.01.01-ний өдрөөс 2025.05.31-ний өдрийг хүртэлх төмөр замын тээврийн байгууллагуудын тээвэрлэсэн ачааны хоног бүрийн мэдээг графикаар харуулав. /Зураг 21/

3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ

Төмөр замаар 2025 оны эхний 5 сард 15.1 мянган зорчигч олон улсад тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.4%-аар өссөн байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Хүснэгт 11 Өсөлт бууралтын % /өссөн дүн/
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	173.25	773.7	144.1	688.2	-11.0%
Олон улс	мян.хүн	3.52	11.0	5.2	15.1	36.4%
Орон нутаг	мян.хүн	169.7	762.7	138.8	673.1	-11.7%
Зорчигч эргэлт	сая хүн.км	64.13	300.1	56.0	280.6	-6.5%


2025 оны 5 дугаар сард нийт 144.1 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 16.8%-аар буурсан. Үүнээс олон улсад 5.2 мянган зорчигч зорчсон нь 47.7%-аар өссөн бол орон нутагт 138.8 мянган зорчигч зорчсон нь 18.2%-аар буурчээ.



Өссөн дүнгээр нийт 688.2 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 11%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 15.1 мянган зорчигч зорчсон нь 36.4%-аар өссөн бол харин орон нутагт 673.1 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 11.7%-аар буурсан байна. Зорчигч эргэлт 280.6 сая хүн км болсон нь өмнөх оны мөн үеэс 6.5%-аар буурчээ.

Зорчигч тээвэрлэлт буурсан гол шалтгаан нь төмөр замын зорчигч тээврийн 98%-ийг эзэлж буй орон нутагт зорчих зорчигчдын тоо тогтмол буурч байгаатай холбоотой бөгөөд зорчигчид орон нутагт вагоноор зорчихоос илүү автомашинаар зорчих нь нэмэгдсэн байна. /Зураг 22/

Зураг 23. Төмөр замын зорчигч, хоногоор



2025.01.01-2025.05.31-ний өдрүүдэд Улаанбаатар төмөр замаар зорчсон зорчигчийн тоог хоногоор нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформуус нэгтгэн гаргав. 2025 оны эхний 5 сарын байдлаар төмөр замаар хоногт дундажаар 4.2 мянган зорчигч зорчиж байна. /Зураг 23/


БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР

4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА

Хүснэгт 12

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
			5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа, шуудан тээвэр	тн	784.3	3,730.6	883.3	3,813.5	2.2%
2	олон улсад	тн	782.5	3,721.7	879.1	3,796.9	2.0%
3	орон нутагт	тн	1.8	8.9	4.2	16.7	88.1%
4	Нийт ачаа	тн	766.2	3,634.7	869.2	3,733.2	2.7%
5	олон улсад	тн	764.5	3,625.9	865.0	3,716.7	2.5%
6	орон нутагт	тн	1.7	8.8	4.2	16.5	87.1%
7	Нийт шуудан	тн	18.1	95.9	14.1	80.4	-16.2%
8	олон улсад	тн	18.0	95.8	14.1	80.1	-16.3%
9	орон нутагт	тн	0.1	0.1	0.0	0.2	214.3%
10	Ачаа эргэлт	мян.тн-км	2,291.4	12,138.1	1,895.63	9,613.6	-20.8%
11	олон улсад	мян.тн-км	2,290.4	12,133.3	1,893.40	9,602.8	-20.9%
12	орон нутагт	мян.тн-км	1.0	4.8	2.2	10.8	124.0%

Зураг 24. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан



Агаарын тээврээр 2025 оны 5 дугаар сард 883.3 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 12.6%-аар өссөн. Үүнээс ачаа 869.2 тонн болж 13.4%-аар өссөн бол шуудан 14.1 тонн болж 16.2%-аар буурсан үзүүлэлттэй байна.


Харин өссөн дүнгээр 3813.5 тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 2.2%-аар өссөн байна. Үүнээс ачаа 3733.2 тонн тээвэрлэсэн нь 2.7%-аар өссөн бол шуудан 80.4 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 16.2%-аар буурсан байна. /Зураг 24/

2025 оны өссөн дүнгээр олон улсад тээвэрлэсэн ачаа шуудан 3796.9 тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 2%-аар, орон нутагт тээвэрлэсэн ачаа шуудан 16.7 тонн болж өмнөх оны мөн үеэс 88.1%-аар тус тус өссөн байна. /Зураг 25/


Агаарын тээврээр тээвэрлэсэн нийт ачаа шуудангийн 99.6%-ийг олон улсад тээвэрлэсэн бол 0.4%-ийг орон нутагт тээвэрлэсэн байна. Мөн нийт ачаа шуудангийн 97.9%-ийг ачаа эзэлж байгаа бол 2.1%-ийг шуудан эзэлж байна.

Ачаа эргэлт 2025 оны өссөн дүнгээр 9.6 сая тонн км болсон нь өмнөх оны мөн үеэс 20.8%-аар бууржээ.

Зураг 25. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан




Зураг 26. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар



4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

Агаарын тээврээр 2025 оны эхний 5 сард нийт 813 мянган зорчигч тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 13.8%-аар өслөө.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Хүснэгт 13 Өсөлт бууралтын %/өссөн дүн/
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Нийт зорчигч тээвэр	хүн	163,849	714,338	176,470	813,024	13.8%
Олон улсад	хүн	126,585	546,455	140,592	644,235	17.9%
Орон нутагт	хүн	37,264	167,883	35,878	168,789	0.5%
Зорчигч эргэлт	мян.хүн км	348,396.1	1,647,783.6	373,121.0	1,969,376.0	19.5%
Олон улсад	мян.хүн км	325,090.8	1,545,938.8	354,452.0	1,875,119.0	21.3%
Орон нутагт	мян.хүн км	23,305.3	101,844.9	18,669.0	94,257.0	-7.5%




2025 оны 5 дугаар сард агаарын тээврээр нийт 176.5 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 7.7%-аар өссөн. Үүнээс олон улсад 140.6 мянган зорчигч зорчиж 11.1%-аар өссөн бол орон нутагт 35.9 мянган зорчигч зорчиж өмнөх оны 5 дугаар сараас 3.7%-аар буурсан байна.

Өссөн дүнгээр нийт 813 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 13.8%-аар өссөн бол үүнээс олон улсад 644.2 мянган зорчигч зорчсон нь 17.9%-аар, орон нутагт 168.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 0.5%-аар тус тус нэмэгдсэн байна. /Хүснэгт 14/

Сар бүрийн зорчигч тээврийн үзүүлэлтийг харахад 6 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл ачаалал нэмэгдсэн нь зуны улиралд аялал жуулчлалын зорилгоор зорчих иргэдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байна./Зураг 28 /

Зураг 28. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар




Зорчигч эргэлт 2025 оны өссөн дүнгээр 1,969.4 сая хүн км болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.5%-аар өссөн. Үүнээс олон улсын зорчигч эргэлт 1,875.1 сая хүн км болж 9.0%-аар өссөн бол орон нутгийн зорчигч эргэлт 94.3 сая хүн км болж 7.5%-аар буурсан байна.

4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ

Хүснэгт 14

№	Үзүүлэлт	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
1	Олон улсад	126,585	546,455	140,592	644,235	17.9%
2	чиглэл Сөүл	44,780	178,500	42,430	191,610	7.3%
3	Бээжин	20,400	91,410	24,600	105,919	15.9%
4	Токио	9,762	43,446	12,915	54,792	26.1%
5	Истанбул	12,832	53,048	12,801	50,245	-5.3%
6	ХонКонг	6,027	31,342	8,292	40,607	29.6%
7	Франкфурт	4,631	23,081	6,050	26,982	16.9%
8	Бусан	8,206	17,084	8,849	21,580	26.3%
9	Хөх хот	4,435	16,667	3,297	21,183	27.1%
10	Фукуок	0	18,071	0	19,026	5.3%
11	Санья/Хайнань	801	5,533	1,941	13,722	148.0%
12	Бангкок	0	10,927	0	13,558	24.1%
13	Хо Ши Мин	0	1,891	0	11,068	485.3%
14	Пукет	0	7,900	0	9,405	19.1%
15	Алмата	1,906	7,137	2,733	8,082	13.2%
16	Чонжү	644	644	4,229	7,011	988.7%
17	Ордос	0	0	1,466	6,198	-
18	Эрхүү	1,383	5,958	1,303	6,123	2.8%
19	Бусад чиглэлд	10,778	35,632	9,686	37,124	4.2%


Зураг 29. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр



2025 оны эхний 5 сарын байдлаар олон улсад нийт 644.2 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 17.9%-аар өссөн. Сөүл чиглэлд 191.6 мянган зорчигч (+7.3%), Бээжин хотруу 105.9 мянган зорчигч (+15.9%), Токио чиглэлд 54.8 мянган зорчигч (+26.1%), Истанбул хотруу 50.2 мянган зорчигч (-5.3%), ХонгКонг чиглэлрүү 40.6 мянган зорчигч (+29.6%), Франкфурт чиглэлд 30 мянган зорчигч (+16.9%) тус тус тээвэрлэсэн байна. Үүнээс Чонжү, Хо Ши Мин, Хайнань чиглэлд зорчигчийн тоо эрс нэмэгдсэн нь гадагшаа чиглэсэн аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбоотой байна. /Зураг 29/

Олон улсад зорчсон зорчигчдын 49% буюу 315.2 мянган зорчигч үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК нислэгээр ниссэн бол “Айрчайна”-ийн нислэгээр 63 мянга, “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр 58.8 мянга, “Корейн айр”-ийн нислэгээр 57.9 мянга, “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр 41.3 мянга, “Туркиш эйрлайнс” ХХК-ын нислэгээр 29.2 мянга, Жэжү айр нислэгээр 24.5 мянга, Ашиана эйрлайнс нислэгээр 16.6 мянга, Вьетжет айр нислэгээр 7.8 мянга, АероК нислэгээр 6.6 мянга, Ираеро нислэгээр 5.9 мянган зорчигч, Т-вей нислэгээр 3.8 мянга, Юнайтед эйрлайнс нислэгээр 2999 зорчигч зорчсон байна. /Зураг 30/

Зураг 30. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь




4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ

Хүснэгт 15

№	Үзүүлэлт	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
1	Орон нутагт зорчигч тээвэр	37,264	167,883	35,878	168,789.0	0.5%
2	чиглэл Оюутолгой	31,467	146,683	30,647	146,550	-0.1%
3	Ховд	1,559	5,392	1,579	6,649	23.3%
4	Өлгий	974	3,690	1,247	5,508	49.3%
5	Алтай	869	3,384	639	2,662	-21.3%
6	Мөрөн	416	1,517	559	2,489	64.1%
7	Улиастай	548	2,284	542	2,454	7.4%
8	Улаангом	514	1,438	556	2,363	64.3%
9	Бусад	0	234	109	114	-51.3%


Зураг 31. Орон нутгийн зорчигч, чиглэлээр



2025 оны 5 дугаар сард орон нутагт нийт 35.9 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 3.7%-аар буурсан байна.

Оны эхнээс өссөн дүнгээр орон нутагт нийт 168.8 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 0.5%-аар өссөн байна. Мөрөн, Улаангом, Өлгий чиглэлд зорчигчийн тоо нэмэгдсэн хэвээр байна. /Хүснэгт 15/

Зураг 32. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь



2025 оны өссөн дүнгээр агаарын тээврээр орон нутагт зорчигчдын 67% буюу 112.1 мянган зорчигч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр, 22% буюу 37.9 мянган зорчигч “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр, 11% буюу 18.7 мянган зорчигч “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр, захиалгат нислэгээр 113 зорчигч тус тус зорчсон байна. Орон нутаг “МИАТ” ХХК-ийн зорчигч 5.7%-аар, “Аэро Монголиа” ХХК зорчигч 7.3%-аар тус тус нэмэгдсэн бол “Хүннү эйр” ХХК-аар зорчсон зорчигчийн тоо 29.7%-аар буурсан үзүүлэлттэй байна. /Зураг 32/

4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ

Хүснэгт 16

Үзүүлэлт	2024 он		2025 он		Өсөлт, бууралтын % /өссөн дүн/
	5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Нийт нислэгийн тоо	7,257	32,960	8,609	39,729.0	20.5%
Олон улсын өнгөрөлтийн нислэг	5,298	25,295	6,605	31,106.0	23.0%
Хөөрөлт, буулт	1,959	7,665	2,004	8,623.0	12.5%
Олон улсын хөөрөлт, буулт	1,030	4,312	1,112	4,855.0	12.6%
Орон нутгийн хөөрөлт, буулт	929	3,353	892	3,768.0	12.4%

2025 оны 5 дугаар сард нийт нислэгийн тоо 8,609 болж өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 18.6%-аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 6,605 болж 24.7%-аар тус тус өссөн байна. Олон улсын хөөрөлт, буулт 1,112 болж 8%-аар өссөн бол орон нутгийн хөөрөлт, буултын тоо 892 болж 4%-аар буурсан байна.

2025 оны эхний 5 сард нийт нислэгийн тоо 39,729 болж өмнөх оны мөн үеэс 20.5%-аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 31,106 болж өмнөх оны мөн үеэс 23%-аар, олон улсын хөөрөлт, буултын тоо 4,855 болж өмнөх оны мөн үеэс 12.6%-аар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 3,768 болж 12.4%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 33/

Зураг 33. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар

